



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑᠘ оны ᠐᠑ сарын ᠐᠘ өдөр

Дугаар А/᠑᠑5

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Нарлаг 3-332 тоот)-т байршилтай иргэн Адъяа овогтой Мөнхбаяр (ЗЮ:75011911)-ын худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор зориулалттай 508 м.кв (0,05га) газрыг иргэн Даваасамба овогтой Отгонбаатар (ЗИ:84081418)-т зориулалтаар нь шилжүүлж 21 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 01 дугаар сарын 06-ний өдрийн А/14 дугаар захирамж газар эзэмших 000051176 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481 015 30